



ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ШИЛЖУУЛЭН ӨГӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид "Талууд" гэнэ)

бис биений бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай байх үндсэн дээр гэмт этгээдийг шилжүүлэн өгөх салбарт хоёр улсын эрх зүйн хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхийг эрмэлзэн,

дараах зүйлийг хэвлэлцэн тохирв. Үүнд:

1 дүгээр зүйл Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үүрэг

Талууд яллах, шүүн таслах ажиллагаа явуулах, эсхүл ял оногдуулах буюу эдлүүлэх зорилгоор Хүсэлт гаргагч Талаас шилжүүлэн өгөхийг хүссэн аливаа этгээдийг энэхүү Гэрээний дагуу бие биедээ шилжүүлэн өгч байхаар тохиролцов.

2 дугаар зүйл Гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг

1. Энэхүү Гэрээний зорилгоор, гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэдэг нь хүсэлт гаргагч үед, хоёр Талын аль алины хуудь тогтоомжийн дагуу нэг жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл түүнээс хүнд ял оногдуулах гэмт хэргийг хэлнэ.

2. Шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь шилжүүлбэл зохих гэмт хэргийн төлөө Хүсэлт гаргагч Талын шүүхээс хорих ял авсан этгээдэд холбогдолтой бөгөөд тухайн хорих яланы үлдсэн хугацаа нь зургаан (6) сараас доошгүй бол гэмт этгээдийг шилжүүлэн өгнө.

3. Энэ зүйлийн зорилгоор, гэмт хэргийг хоёр Талын аль алины нь хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг тогтоохдоо:

а/ Талуудын хууль тогтоомжид гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдлийг хуулийн нэг зүйлээр зүйлчилэх, эсхүл ижил иэр томъёогоор тодорхойлж буй эсэхийг үл харгалзана;

б/ шилжүүлэн өгөхийг хүссэн этгээдийн үйлдсэн үйлдлийг нийтэд нь харгалзан үзэж, гэмт хэргийн үйлдлийн элементүүдийг Талуудын хууль тогтоомжид оөр оөрөөр заасан эсэхийг үл харгалзана.

4. Шилжүүлэн өгөх этгээд нь татвар, гаалийн хураамж, гадаад валютын солилцоонд тавих хяналт болон орлоготой холбогдолтой бусад хуулиудыг зөрчсөн бол Хүсэлт хүлээн авагч Талын хуулиар ижил торийн татвар буюу хураамж оногдуулдагтүй, эсхүл Хүсэлт гаргагч Талын хуульд заасантай ижил торийн татвар, хураамж, гааль буюу валютын асуудлаар зохицуулалттүй гэсэн үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзахгүй.

5. Хэрэв тухайн гэмт хэрэг нь Хүснэгт гаргагч Талын нутаг дэвсгэрээс гадна үйлдэгдсэн боловч Хүснэгт хүлээн авагч Талын хууль тогтоомжид өөрийн нутаг дэвсгэрээс гадна ижил төстэй нохцолд үйлдэгдсэн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулдаг бол гэмт этгээдийг шилжүүлэн огно. Хэрэв Хүснэгт хүлээн авагч Талын хууль тогтоомжил ийнхүү заагаагүй бол Хүснэгт хүлээн авагч Тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх эсэхийг өөрөө шийдвэрлэнз.

6. Хэрэв шилжүүлэн өгөх тухай хүснэгт нь хэд хэдэн гэмт хэргийг хамарч буй бөгөөд тэдгээр нь Талуудын хууль тогтоомжийн дагуу бүгд шийтгэгдэл зохих гэмт хэрэг боловч зарим нь эн зүйлийн 1 ба 2 дахь заалтад заасан бусад нехцэлтэй нийцэхгүй бол тухайн этгээдийн үйлдсэн шилжүүлбэл зохих нэгээс доошгүй гэмт хэрэгт нь холбогдуулан шилжүүлэн өгч болно.

З дугаар зүйл Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах

Дараах тохиолдолд энэхүү Гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй. Үүнд:

1/ Хүснэгт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгт холбогдолтой гэмт хэрэг хэмээн тодорхойлсон бол. Гэхдээ дараах гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэгт хамааруулахгүй. Үүнд:

a/ Төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, эсхүл тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь насанд халдсан, эсхүл халдахаар завдсан бол;

b/ аймаглан устгах, алан хядах болон бусдыг барьцаанд авах тухай олон улсын олон талт гэрээ хэлэлцээрт хоёр Тал хоёулаа нэгдэн орсоноор ийм гэмт хэргийг шүүх, эсхүл шилжүүлэн өгөх үүрэг хүлээсэн бол;

2/ эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлж авахаар хүснэгт болгосон тухайн гэмт хэрэгт нь холбогдуулан Хүснэгт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татах шүүхээр шийтгэн ялласан, эсхүл цагаатгасан бол;

3/ шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэрэгтэй ижил төст гэмт хэрэг Хүснэгт хүлээн авагч Талд үйлдэгдсэн бөгөөд Хүснэгт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн хөөн хэлэлцэх хугацаа дуусан зогсоосон бол. Хүснэгт гаргагч Талын хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааг зогсоох талаархи үйлдэл, нехцэл байдлын тухай заалтыг Хүснэгт хүлээн авагч Тал харгалзан үзэх бөгөөд эл зорилгоор Хүснэгт гаргагч Тал өөрийн хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацааны тухай холбогдох заалтуудын талаар бичгээр мэдэгдэнз.

4/ гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүснэгт нь эрэн сурвалжилж буй этгээдийг арьс онгө, шашин шүтлэг, иргэний харьялал, хүйс, эсхүл улс төрийн үзэл болдоор нь яллах буюу ял шийтгэх гэж байгаа, эсхүл шүүн таслах ажиллагааны үеэр дээрхи шалтгаанаар хохироо бодитой үндэслэлтэй хэмээн Хүснэгт хүлээн авагч Тал үзсэн бол.



4 дүгээр зүйл Шилжүүлэн огохөөс татгалзаж болох үндэслэл

Энэхүү Гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг дараах аль ч тохиолдолд татгалзаж болно. Үүнд:

1. шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэргийг Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжоор өөрийн нутаг дэвсгэр дээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн үйлдсэн хэмээн үзсэн бол;
2. эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн хэрэгтэй нь холбогдуулан аль нэг гуравдагч улсад гэм буруугүй, гэм буруутай хэмээн эцсийн шийдвэр гаргасан, эсхүл гэм буруутай нь тогтоогдож оногдуулсан ял шийтгэлийг бүрэн эдлүүлсэн буюу эдлүүлж дууссан бол;
3. онцгой тохиолдолд Хүсэлт хүлээн авагч Тал тухайн гэмт хэргийн хүнд, хөнгөн болон Хүсэлт гаргагч Талын ашиг сонирхолыг харгалзан үзэхийн хамтаар, эрэн сурвалжилж буй тухайн этгээдийн хувийн нөхцөл байдлаас шалтгаалан ийнхүү шилжүүлэн өгөх нь хүмүүнлэгийн үүднээс нийцэхгүй байна хэмээн үзвэл;
4. шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэрэг нь энгийн эрүүгийн хэрэг бус, цэргийн гэмт хэрэгт хамааралтай бол.

5 дугаар зүйл Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Хүсэлт хүлээн авагч Тал тухайн эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэргээс өөр гэмт хэргээр шүүж байгаа, эсхүл тухайн этгээд өөр гэмт хэргийн улмаас ял здэлж буй бол Хүсэлт хүлээн авагч Тал эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлэн өгөх, шүүн таслах ажиллагаа дуусгах, оногдуулсан ялын хугацааг бүхэлд нь буюу зарим хэсгийг здэлж дуустал шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

6 дугаар зүйл Иргэний харьяаллаар нь шилжүүлэн өгөх

1. Аль ч Тал өөрийн иргэнийг энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгөхгүй.
2. Эрэн сурвалжилж буй этгээдийг зөвхөн иргэний харьяаллыг нь үндэслэн шилжүүлэн өгөхөөс татгалзаж буй боловч Хүсэлт гаргагч Тал хэрэв хүсвэл тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн эрх бүхий байгууллагад ял шийтгүүлэхээр шилжүүлэн өгнө.
3. Иргэний харьяаллыг нь тодорхойлохдоо шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэргийг үйлдэх үедээ аль улсад харьяалагдаж байсныг нь үндэс болгоно.

7 дугаар зүйл Харилцах суваг

Шилжүүлэн өгөхийг хүссэн хүсэлт бэлон бусад аливаа харилцааг дипломат шугамавар дамжуудна.



8 дугаар зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх журам,
шаардлагдах бичиг баримт

1. Шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгтийг бичгээр үйлдэнэ. Энэхүү Гэрээний зорилгоор шилжүүлэн өгөх тухай хүснэгт болон бусад бичиг баримтын эх хувь болон түүний баталгаатай хуулбарыг аливаа хэлбэрээр дахин баталгаажуулахгүй.
2. Шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгтэд дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд:
 - а) эрэн сурвалжилж буй этгээдийн шинж тэмдгийг тайлбарласан бичиг баримт, хэрэв боломжтой бол иргэний харьялал болон тухайн этгээдийн байршил;
 - б) гэмт хэргийн үндсэн элементүүдийг тайлбарласан хуулийн холбогдох заалтын талаархи мэдээлэл, гэмт хэргийн зорилго;
 - в) гэмт хэргэг оногдуулж буй ял шийтгэлийг тайлбарласан хуулийн холбогдох заалтын талаархи тайлбар;
 - г) гэмт хэргийг шийтгэх болон оноосон ялын хугацааны талаархи хуулийн холбогдох заалтын талаархи мэдээлэл.
3. Шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгт нь гэм буруутай нь тогтоогдоогүй аль нэг этгээдтэй холбоотой бол дараах бичиг баримтыг дагалдуулна. Үүнд:
 - а) Хүснэгт гаргагч Талын шүүгч болон эрх бүхий албан тушаалтны гаргасан баривчлах, эсхүл saatuuлах тухай зөвшөөрлийн хуулбар;
 - б) тухайн эрэн сурвалжилж буй этгээдийг баривчлах, эсхүл saatuuлах зөвшөөрөл нь тухайн этгээдэд холбогдож буйг тогтоосон бичиг баримт;
 - в) эрэн сурвалжилж буй этгээд нь шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн гэмт хэргийг үйлдсэнийг сэжиглэх бодитой үндэслэл байгаа бол энэ талаархи баримт.
4. Шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгт нь гэм буруутай нь тогтоогдсон аливаа этгээдтэй холбоотой бол дараах бичиг баримтыг дагалдуулна. Үүнд:
 - а) хүснэгт гаргагч Талын шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын хуулбар;
 - б) эрэн сурвалжилж буй тухайн этгээдийн гэм буруутайг нь тогтоосон тухай мэдээлэл;
 - в) тухайн этгээдийн гэм буруутай хэмээн тогтоогдсон гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай баримт;
5. Хүснэгт гаргагч Талаас энэхүү Гэрээний заалтуудын дагуу гаргах бүхий л бичиг баримтыг Хүснэгт хүлээн авагч Талын хэл дээр орчуулсан орчуулагыг хавсаргах буюу эсхүл англи хэл дээр үйлдэнэ.



9 дүгээр зүйл Нэмэлт мэдээлэл

- Хэрэв Хүснэгт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгт болон бусад мэдээлэл нь энэхүү Гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөд хангалттай бус хэмээн үзвэл тухайн Тал тодорхой хугацаа зааж, уг хугацааны дотор нэмэлт мэдээлэл авахыг хүсч болно.
- Шилжүүлэн өгөхийг хүссэн эрэн сурвалжилж буй этгээдийг баривчилсан боловч нэмэлт мэдээлэл нь энэхүү Гэрээний хүрээнд хангалттай бус мөн уг мэдээллийг тогтоосон хугацаанд хүлээн аваагүй бол тухайн этгээдийг суллаж болно. Ийнхүү суллах нь тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай Хүснэгт гаргагч Тал дахин хүснэгт гаргахад саад болохгүй.
- Хүснэгт хүлээн авагч Тал энэ зүйлийн 2 дахь заалтын дагуу аливаа этгээдийг суллан тавьсан бол энэ тухайгаа Хүснэгт гаргагч Талд аль болох бодитой түргэн хугацаанд мэдэгдэнэ.

10 дугаар зүйл Урьдчилан баривчлах

- Оиц яаралтай тохиолдолд, шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгтийг бүрэлдүүлж амжаагүй бол аль нэг Тал аливаа эрэн сурвалжилж буй этгээдийг урьдчилан баривчлах тухай хүснэгт тавьж болно. Урьдчилан баривчлах тухай хүснэгтийг дипломат шутамаар, эсхүл хоёр Талын Хууль зүйн яамд хооронд шууд тавина.
- Урьдчилан баривчлах тухай хүснэгтийг бичгээр үйлдэх бөгөөд дараах зүйлийг агуулсан байна. Үүнд:
 - эрэн сурвалжилж буй этгээдийн шинж тэмдгийн талаархи тайлбар, түүний иргэний харьяалал;
 - хэрэв тогтоогдсон бол тухайн этгээдийн байршил;
 - тухайн хэргийн талаархи товч танилцуулга, боломжтой бол гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа;
 - зөрчсон хууль тогтоомжийн талаархи тайлбар;
 - эрэн сурвалжилж буй этгээдийг баривчлах болон албадан саатуулах тухай зөвшөөрөл байгаа эсэх, эсхүл түүний буруутайг тогтоосон баримт, түүнд ял шийтгэсэн таслан шийдвэрлэх тогтоол зэргийн талаархи мэдээлэл;
 - тухайн эрэн сурвалжилж буй этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгтийг дараа нь өгөх тухай мэдэгдэл.
- Ийм хүснэгтийг хүлээн авсан Хүснэгт хүлээн авагч Тал тухайн этгээдийг баривчлах талаар шаардлагатай арга хэмжээ авч, баривчлах үйл ажиллагааны үр дунг Хүснэгт гаргагч Талд мэдэгдэнэ.
- Хэрэв хүснэгт гаргагч Тал шилжүүлэн өгөхийг хүссэн хүснэгтийг энэхүү Гэрээний 8 дугаар зүйлд заасан бичигт баримтын хамтаар тухайн этгээдийг баривчилсан



одрөөс хойш 45 хоногийн хугацаанд огч чадаагүй богоод хэрэв энэ нь шилжүүлэн өгөхийг хүссөн хүсэлтийг дараа нь хүлээн авсан тохиолдолд түүнд ял шийтгэл оногдуулахад саал болохгүй бол тухайн баривчлагдсан этгээдийг судлан тавина.

11 дүгээр зүйл Шилжүүлэн өгөхийг түргэвчилэх

Эрэн сурвалжлагдаж буй этгээд нь Хүсэлт гаргагч Талын шүүх буюу эрх бүхий байгууллагад гаргасан шилжүүлэн өгөхийг хүссэн хүсэлтийг зөвшөөрч буй тухайгаа мэдэгдэвэл, Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгөх үйл ажиллагааг түргэвчлэх талаар бүхий л арга хэмжээг өөрийн хууль тогтоомжийн дагуу авна.

12 дугаар зүйл Нэгэн зэрэг гаргасан хэдэн хүсэлт

1. Хэрэв аль нэг этгээдийг нэг төрлийн эсхүл өөр өөр төрлийн гэмт хэргийн улмаас шилжүүлэн өгөхийг хоёр буюу түүнээс дээш тооны улс нэгэн зэрэг хүсэж, хүсэлт гаргасан бол Хүсэлт хүлээн авагч Тал этгээр улсын алинд нь тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай шийдвэрлэж, өөрийн шийдвэрийн талаар эдгэр Улсад мэдэгдэнс.

2. Ямар Улсад тухайн этгээдийг шилжүүлэн огох тухай шийдвэр гаргахдаа Хүсэлт хүлээн авагч Тал холбогдох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх богоод, чингэхдээ:

- а) эрэн сурвалжилж буй этгээдийн иргэний харьжалал, байнга оршин суудаг газар;
- б) эдгэр хүсэлтийг энэхүү Гэрээний дагуу гаргасан эсэх;
- в) гэмт хэрэг тус бүрийн үйлдэгдсэн газар, цаг хугацаа;
- г) хүсэлт гаргасан улсын холбогдох ашиг сонирхол;
- д) гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал;
- е) хохирогчийн иргэний харьжалал;
- ж) Хүсэлт гаргагч улс өөр хоорондоо дахин шилжүүлэн өгөх боломж бий эсэх;
- ж) хүсэлт гаргасан одор.

13 дугаар зүйл Хүлээлгэн өгөх

1. Хүсэлт хүлээн авагч Тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийн талаар зохих шийдвэр гарсан даруй Хүсэлт гаргагч Талд дипломат шугамаар мэдэгдэнс. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг бүхээлд нь буюу хэсэгчилэн татгалзсан бол шалтгааныг заана.



2. Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн эрэн сурвалжилж буй гэмт этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт хоёр талын харилцан тохиролцсон аль нэг газар, Хүсэлт гаргагч Талын эрх бүхий зохих байгууллагад хүлээлгэн өгнө.
3. Хүсэлт гаргагч Тал тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын заасан бодитой хугацааны дотор Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрээс гарган авах бөгөөд энэ хугацаанд тухайн этгээдийг гарган аваагүй бол Хүсэлт хүлээн авагч Тал түүнийг суллах тухайн гэмт хэрэгт нь холбогдуулан шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.
4. Аль нэг Тал өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас шилжүүлэн өгөх тухайн гэмт этгээдийг хүлээлгэн өгөөгүй, эсхүл хүлээн аваагүй бол энэ тухайгаа негеэ Талдаа мэдэгдэнэ. Хоёр Тал гэмт этгээдийг хүлээлгэн өгөх буюу хүлээн авах шинэ хугацааг харилцан тохиролцох бөгөөд энэ зүйлийн З дахь заалтыг баримтална.

14 дүгээр зүйл Эд хөренгэ хүлээлгэн өгөх

1. Хэрэв гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөр болсон бол Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомж болон аль нэг гуравдагч этгээдийн эрх ашгийг бүрэн хүндэтгэх үндсэн дээр, гэмт хэргийн улмаас олсон бөгөөд Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт илэрсэн бүхий л эд хөренгийг нотлох баримт болгон ашиглах зорилгоор Хүсэлт гаргагч Талын хүсэлтээр хүлээлгэн өгнө.
2. Энэ зүйлийн 1 дэхь заалтыг баримтлан дээр дурьдагдсан эд хөренгийг гэмт этгээд нас барсан буюу оргон зайлсан аль ч нехцелд хэрэв Хүсэлт гаргагч Тал ийнхүү хүсвэл хүлээлгэн өгнө.
3. Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжоор, эсхүл аливаа гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах үүднээс хүлээлгэн өгсөн эд хөренгийг эргүүлэн өгөх шаардлагатай бөгөөд Хүсэлт хүлээн авагч Тал ийнхүү хүсвэл, эд хөрөнгийг тухайн Талд үнэ төлбөргүй эргүүлэн өгнө.

15 дугаар зүйл Оицгой журам

1. Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгсөн аливаа этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн хэргээс өөр өмнө нь үйлдсэн ямар нэг гэмт хэрэгт холбогдуулан саатуулах, яллах буюу шийтгэх, эсхүл аль нэг гуравдагч улсад дор дурьдсанас бусад тохиолдолд, ямар нэг гэмт хэргийн төлөө шилжүүлэн өгөхгүй. Үүнд:
 - a/ шилжүүлэн өгсөний дараагаар тухайн этгээд нь Хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрийг орхин гарсан боловч сайн дураар буцаж ирсн бол;
 - b/ тухайн этгээд нь Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрийг дочин тав /45/ хоногийн дотор чөлөөтэй орхин гарах ёстой боловч ийнхүү орхин гарваагүй бол; мөн,
 - v/ Хүсэлт хүлээн авагч Тал зөвшөөрсөн бол. Ийнхүү зөвшөөрхийг хүссэн хүсэлтийг 8 дугаар зүйлд дурьдсан бичиг баримт болон тухайн хэрэгт холбогдох буй шилжүүлэн өгсөн этгээдийн мэдэгдэлийн хамт илгээн.



Зөвшөөрөлийг хэрэв энхүү Гэрээний дагуу шилжүүлбэл зохих гэмт хэрэг мөн бол өгч болно.

2. Энэ зүйлийн I дэхь заалт нь шилжүүлэн огсний дараа үйлдэгдсэн гэмт хэрэгт хамаарахгүй.

16 дугаар зүйл
Үр дүнг мэдэгдэх

Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгсөн тухайн этгээдийг ял шийтгэсэн, шүүхийн хүчин тогтолцоог хэрэгжүүлсэн, эсхүл тухайн этгээдийг аль нэг гуравдагч улсад дахин шилжүүлэн өгсөн талаархи мэдээллийг Хүсэлт хүлээн авагч Талд тухай бүр мэдэгдэж байна.

17 дугаар зүйл
Дамжин өнгөрөх

1. Аль нэг гуравдагч Улсаас ногоо Талд хүлээлгэн өгч буй аливаа этгээдийг Талуудын аль нэгний нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх бол ийнхүү дамжин өнгөрүүлэх тухай хүсэлтийг дипломат шугамаар, бичгээр тавих бөгөөд тухайн Талын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгоно.

2. Хэрэв дамжин өнгөрүүлэх Талын нутаг дэвсгэрт газардалгүй, агаарын тээвэрээр шууд дамжин өнгөрөх бол дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл шаардлагдахгүй. Хэрэв тухайн Талын нутаг дэвсгэрт гэнт буух шаардлагагаа тарвал, энэ зүйлийн I дэхь заалтад заасны дагуу дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл авах хүсэлтийг гаргаж болно.

18 дугаар зүйл
Зардал

1. Хүсэлт хүлээн авагч Тал гэмт этгээдийг шилжүүлэн огохоеос үүдэн өөрийн хууль тогтоомжийн хүрээнд явуулах аливаа шүүх ажиллагааны зардлаа хариуцна.

2. Хүсэлт хүлээн авагч Тал эд хөрөнгийг хураан авах болон хүлээлгэн өгөх, эсхүл шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн эрэн сурвалжилж буй этгээдийг баривчлах болон албадан саатуулахтай холбогдсон өөрийн нутаг дэвсгэр дээрхи зардлыг хариуцана.

3. Хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрээс шилжүүлэн авах болон дамжин өнгөрөх зардлыг хариуцана.

19 дүгээр зүйл
Зөвшилцөх

Аль нэг Талын хүсэлтээр, энхүү Гэрээг тайлбарлах болон хэрэгжүүлэх талаар Талууд зөвшилцож байна.

20 дугаар зүйл
Хүчин тогтолцоог болох, шулах

1. Энхүү Гэрээг соёрхон батлана. Энхүү Гэрээ нь түүнийг соёрхон баталсан тухай Батламж Жуух бичгүүдийг солилцсоноор хүчин тогтолцор болно.



2. Энэхүү Гэрээ нь түүнийг хүчин тоголдор болсноос хойш болон өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт ишгэн адил хамаарна.

3. Аль иэг Талд негеө Талд бичгээр мэдэгдэн, энэхүү Гэрээг хэдийд ч цуцлаж болно. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 6 сарын дараа энэхүү Гэрээ хүчнингүй болно.

ДЭЭРХИЙГ НОТЛОН тус тусын Засгийн газраас зохих ёсны эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо, 1999 оны 5 дугаар сарын 31 -ны өдөр монгол, солонгос, англи хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зоруу гарвал англи хэл дээрхи эх бичвэрийг баримтлана.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ